



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/274

Улаанбаатар хот

Чингэлтэй дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын данс бүртгэлээс  
тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/614 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 147,456,000 (нэг зуун дөчин долоон сая дөрвөн зуун тавин зургаан мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тээврийн хэрэгслүүдийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар (П.Баянбаатар)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар (П.Баянбаатар)-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000803

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2021 оны 09 дугаар сарын 17-ний өдрийн  
17/09 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

/төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Автомашины марк, улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар	Исузу 72-41 УБЕ	73,728,000.0	73,728,000.0	0.0
2		Исузу 72-42 УБЕ	73,728,000.0	73,728,000.0	0.0
<b>Дүн</b>			<b>147,456,000.0</b>	<b>147,456,000.0</b>	<b>0.0</b>